



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/287

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгасан "Ойн хөнөөлт шавжийн тэмцлийн ажил (Бугат, Орхон, Хангал, Хутаг-Өндөр 18608 га)"-ыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2026 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу 1 дүгээр багц "Хангал суманд 9220 га талбай"-н ажлын гүйцэтгэгчээр шалгарсан "Хатантфорест" ХХК-тай 307,167,500 (гурван зуун долоон сая нэг зуун жаран долоон мянга таван зуу) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т олгосугай.

2. Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Байгаль орчны газар (А.Гантөмөр)-т үүрэг болгосугай.

3. Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль тогтоомж, стандарт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг "Хатантфорест" ХХК-ийн захирал (Б.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

4. Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр хавсралтаар, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

5. Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг тус сангийн нягтлан бодогч (Б.Очирсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Д.ЛҮРЭВ-ОЧИР



6326010389

Аймгийн Засаг даргын 2026 оны
04 дүгээр сарын 20 -ны/ний өдрийн
А/28 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

| д/д | Нөхцөл шаардлага | Мөнгөн дүн | Хариуцах албан тушаалтан |
|-----|-----------------------|---|--|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Алданги | Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна. | Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс) |
| 2 | Чанарын баталгаа | Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана. | Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс) |
| 3 | Гүйцэтгэлийн баталгаа | 3 хувь | Б.Ариунболд (Санхүү, төрийн сангийн хэлтэс) |

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
 04 дүгээр сарын 20 нын өдрийн
 А/287 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн
 ажилчид, машин механизмын жагсаалт

| Инженер, техникийн ажилчид | | | Хариуцах албан тушаалтан |
|----------------------------|--|---------------|--------------------------------|
| д/д | Албан тушаал | Ажилтны нэр | |
| 1 | 2 | 3 | 4 |
| 1 | Ойн инженер (ерөнхий инженер)-1 | Ө.Мягмаржав | А.Гантөмөр |
| 2 | Шавьж судлаач, биологич-1 | Б.Мөнхцэцэг | |
| 3 | Ой зүйч | Б.Бат-Эрдэнэ | |
| 4 | Ой зүйч | Э.Шанширмаа | |
| 5 | Ой зүйч | Д.Энхжаргал | |
| Машин механизмын жагсаалт | | | |
| д/д | Машин механизмын нэр | Улсын дугаар | |
| 1 | Тэмцлийн ажилд шаардагдах ус зөөвөрлөх ажилд ашиглах бага дунд оврын ачааны автомашин-1 | 8296 УЕН | А.Гантөмөр |
| 2 | Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд шаардагдах шатах тослох материалуудыг зөөвөрлөх бага, дунд оврын автомашин-1 | 8297 УАА | |
| 3 | Тэмцлийн ажилд ажиллах үйлчилгээний автомашин-1 | 7356 УНБ | |
| 4 | Ойн хөнөөлт шавж, өвчинтэй тэмцэх ажилд дуслын хэмжээ нь 400 нанометрээс доошгүй байж мананцар үүсгэн шүрших хүчин чадалтай шүршигч тоног төхөөрөмж-10 | 10 ширхэг | |
| 5 | Агаарын хөлөг, дрон түүнтэй дүйцэхүйц тоног төхөөрөмж-1 | DJI T 50 дрон | |

--о00о--